



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 10 өдөр Дугаар 09

Хэрлэн сум

IX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 09 дүгээр хуралдаан 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 08:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 52,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ш.Ёл даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,
Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.Хуурайшилт ихтэй, түймрийн эрсдэлтэй үед Петрочайна Дачин тамсаг ХХК-ны 19, 21 дүгээр талбайн ажилтан, алба хаагч, техник хэрэгслийг бүхэлд нь дайчлан ажиллуулах, шатахуун, хүнсний хангалтыг шуурхай шийдвэрлэх, түймэр унтрааж байгаа сум болон ОБГ-ын бүлгүүдэд шатахуун олгох талаар тус байгууллагад мэдэгдэх,

3.Сумдын Онцгой комисстой цахим хурал хийж цаг агаарын аюулт үзэгдлийн үед ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгөх,

4.Гамшгийн үед алба, мэргэжлийн ангийн техник, хэрэгслийг дайчлах шийдвэр гаргуулах,


5.Хэрлэн сумын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэгт ажиллаж буй Онцгой байдлын газрын алба хаагчдыг татах, бусад байгууллагаас дайчлан ажиллуулах,

6.Хэрлэн сумын гэр хорооллын айл, өрхүүд хашааныхаа гадаа хогоо асгаж байгаа нь салхи ихтэй үед объектын гал түймрийн дуудлагыг эрс нэмэгдүүлж байгаа тул яаралтай арга хэмжээ авах,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагч,
дэд хурандаа Д.Бямба-д:

1.1.Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Зэвсэгт хүчний 327 дугаар ангиас 50 албан хаагчийг дайчлан ажиллуулах бэлэн байдлыг хангах,

 Ш.Ёл
/ Б.Цогтбаяр

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа-д:

1.2.Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан дайчлан ажиллуулахад шаардагдах зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас шийдвэрлэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

1.3.Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн бүлгийг томилж ажиллуулах, шаардагдах зардлыг тооцож танилцуулах,

Аймгийн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

1.4.Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд Газрын тосны "Петрочайна Дачин тамсаг" ХХК-ийн 19, 21 дүгээр талбайн ажилтан, алба хаагч, техник хэрэгслийг бүхэлд нь дайчлан ажиллуулах, хоол хүнсээр хангах, түймэр унтрааж байгаа бүлгүүдэд шатахууны асуудлыг шийдвэрлэх талаар чиглэл өгч ажиллах,

Улаанзагалмайн хорооны дарга, Онцгой комиссын гишүүн Б.Ганболд-д:

1.5.Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан түймэрт ажиллаж буй албан хаагч, иргэдэд хүнс, ундны усны хангамжийн дэмжлэг үзүүлэх талаар олон нийтэд уриалга гаргах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

1.6.Матад, Халхгол сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан түймэрт ажиллаж буй албан хаагчдад шаардлагатай хүнсний материалын зардалд 4,633,700 төгрөг, хүнс хүргэж өгөх шатахууны зардалд 2,196,320 төгрөг, нийт 6,830,020 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас шийдвэрлэх,

Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Гантулга-д:

1.7.Хэрлэн сумын хэмжээнд томилсон ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэгт Онцгой байдлын газрын алба хаагч нар түр хугацаанд үүрэг гүйцэтгэх боломжгүй тул Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 4 албан хаагчийг ажиллуулахыг тус тус үүрэг болгов.

ОРЛОГЧ ДАРГА

Ш.ЁЛ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР

